



**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

---



# **БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ТАЙЛАНГ ХҮЛЭЭН АВАГЧ:  
ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ**

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА Д.ДЭЛГЭРСАЙХАН**

**2021 ОН**

## АГУУЛГА

Нэг.Зорилт .....	3
Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/.....	3
Гурав. Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн ажлын хүрээнд .....	7
Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа .....	8
4.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :.....	8
4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд: .....	10
4.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд: .....	12
4.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа .....	14
Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа .....	17
Зургаа. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд.....	19
Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Мэдээллийн технологи, программ хангамжийн хүрээнд / .....	20
Найм. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/.....	22
Ёс. Сургалт, үйл ажиллагаа тайлагнах ажлын хүрээнд .....	25
Арав. Идэвх санаачлага, шинэлэг ажил.....	27

# БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## Нэг.Зорилт

Тус хэлтэс нь 2021 онд хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон Хэлтсийн 2021 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат, дамжлагыг багасгах зорилт тавьж ажилласан болно.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх, иргэн, хуулийн этгээдэд цахимаар үйлчилгээ үзүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

### **Хоёр. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд /Улсын бүртгэлийн Ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилт/**

Тус хэлтэс нь улсын бүртгэлийн үйлчилгээг аймгийн нийт иргэд хөдөлмөрчдөд хуулийн хүрээнд хүртээмжтэй, шуурхай хүргэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээний хүртээмжийг нь нэмэгдүүлэх зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр гарын авлага болон бусад материалаар хангаж, бүртгэлийн бүрдүүлбэр хангуулсны үндсэн дээр мэдүүлэг хүлээн авах ажиллагаанд улсын бүртгэгчдийг сургасан болно.

Өнөөдрийн байдлаар эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх, гэрээ хэлцлийг 3 хоногийн дотор, барьцааны гэрээг ажлын 8 цагийн дотор тус тус бүртгэж, улсын бүртгэлийн үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллаж байна.

Дэлхий нийтийг цочроосон COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс халдвар хамгаалалын дэглэмээ хатуу баримтлан иргэдэд онлайн e-mongolia цахим хуудаснаас үйлчилгээ авах талаар мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар болон олон нийтийн радио телевиз, мэдээллийн самбарт байршуулан, хэрхэн ажиллах заавар зөвлөмжийг өгч, түргэн шуурхай үйлчилгээ үзүүлж ажиллаа.



Үйлчилгээний зааланд хүн хоорондын зай авах, үйлчилгээ үзүүлэх цонхонд амны хаалтаа зүүх, гараа арутгах анхааруулга стикерүүд байршуулсан.

Үйлчилгээний зааланд хүн хоорондын зай авах, үйлчилгээ үзүүлэх цонхонд амны хаалтаа зүүх, гараа арутгах анхааруулга стикерүүд байршуулсан.

Хэвлэгдэж ирсэн иргэний цахим үнэмлэх, гадаад паспортуудыг эздэд нь утсаар мэдэгдэж үйлчлүүлэгчидтэй эргэх холбоотой ажиллаж байна. 16 нас хүрээгүй хүүхдийн паспорт олгохдоо “Хилээр гарах тохиолдолд төрсний гэрчилгээг хамт авч явах тухай санамж” бичиг хавсаргаж өгч үйлчилж байна.

УБЕГ-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ын хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэг шилжих үед ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж хэлтсийн даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Хэлтсийн даргын баталсан Ковид-19 халдварт өвчин гарсантай холбогдуулан болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийх цэвэрлэгээний төлөвлөгөөний дагуу ажлын байрандаа их цэвэрлэгээг тогтмол хийж байна.

Сумдын улсын бүртгэгч нарын цаг ашиглалтанд байнгын хяналт тавин ажиллаж байгаа ба өглөө бүр Spark дотоод сүлжээгээр ирцийн бүртгэлийг хянаж байна. Мөн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон сумын ЗДТГ-ын даргаас цаг бүртгэлийн хуудсыг авч хэвшсэн болно. Цахим хуудсанд болон нийгмийн сүлжээний байгууллагын фэйсбук хуудсанд холбоо барих утасны дугаар, цахим шуудан хаяг, цагийн хуваарийг шинэчлэн оруулсан нээлттэй утаснуудыг бичсэн.

2021 онд 16, 25,45 насанд хүрсэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр хамрагдах иргэдэс, иргэний үнэмлэх шинээр авах, дахин авах, сольж авахад бүрдүүлэх материал, 2021 оны 07-р сарын 1-ээс эхэлж мөрдөж эхэлсэн Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосон МУ-ын Засгийн газрын тогтоол, иргэний үнэмлэхийн QR кодыг уншуулж иргэний бүртгэлийн дугаараа мэдэх зэрэг анонс хийж байгууллагын сошиал хуудсаар болон цахим хуудсаар түгээж ажиллав.



Улсын бүртгэлий ерөнхий газраас 2021 оныг "ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ЖИЛ" болгон зарласантай холбогдуулан Баян-Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУЛАН ажлуулав. Мөн хуулийн этгээдийн үүсгэн байгуулахад баримт бичгийг иргэн өөрөө боловсруулалт хийн, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараар ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 22-23-ны өдөр Баян-Өлгий аймагт ажилласан ба ажлын хэсгийн гишүүн Улсын бүртгэлийн Ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан аймаг дахь улсын бүртгэлийн үйл ажиллагаатай танилцаж албан хаагч нарт үүрэг, чиглэл өгч хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулсан.

ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаад байгаа тус хэлтсийн байрны асуудлыг аймгийн архивын тасгийн хамт ирэх оны улсын төсвийн салбарын хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан байртай болгохоор боллоо.



Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын бүртгэлийн Ерөнхий газар болон БНСУ-ын Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага “КОЙКА”-ын хамтран хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх” төслийн хүрээнд тус аймгийн улсын бүртгэлийн анхан шатны бүх нэгжүүдэд суурин компьютер, олон үйлдэлт принтер, хурууны хээ уншигч, зургийн аппарат болон албан хаагчдад Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх халдвар, хамгааллын хэрэслийн хүлээлгэн өгч буй батламжийг гардуулав.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн хяналт шалгалт хийх тухай удирдамж, УБЕГ-ын Хяналт шалгалтын газрын чиглэл, Аймгийн прокурорын газрын шалгалт хийх тухай удирдамжийн дагуу тус аймгийн нутаг дэвсгэрт Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчих зөрчлийг илрүүлэх, шалган шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний хүрээнд нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага иргэдээс үйлчилгээ үзүүлэхдээ үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэх, гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалсан үйлдэл байгаа эсэхийг шалгаж, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцох, дахин энэ төрлийн зөрчил давтан гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх сарын хугацаанд авч хэрэгжүүлэв.





Төрийн байгууллагуудын уялдаа холбоо сайжруулах, нэгдмэл нэг ойлголттой байх, гэмт хэрэг зөрчлийн улмаас үүсэх үр дагавар бий болохоос урьдчилан сэргийлэх, улсын бүртгэл үнэн зөв байх байдлыг хангах ажлын хүрээнд аймгийн Газрын харилцаа хот байгуулалтын газар, Арилжааны банкны удирлагуудтай ажил хэргийн уулзалт зохион байгуулан мэдээлэл солилцож олон асуудалд шийдэл гарцыг олж харилцан тохиролцож ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 7/775 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу давхардаагүй байдлаар ангилж шүүсэн 10011 жагсаалтыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн албан хаагчид нэгбүрчлэн шалгаж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу эрхийн улсын бүртгэлд тусгах мэдээллийг зарлуулах, мэдээллийн санд өөрчлөлт оруулахаар хяналтын улсын байцаагчаар 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 1118 тоот дүгнэлт гаргуулан эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /EPRS/-д зөрчлийг бүрэн гүйцэт арилгасан болно.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 1/4763 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан Хэлтсийн даргын 2021 оны 02 дугаар сарын 04-ны өдөр А/05 дугаартай тушаалаар нийт 6 гишүүнтэй хэлтсийн БНШКомиссыг шинэчлэн байгуулсан ба уг тушаалын дагуу хэлтсийн Бичиг баримт нягтлан шалгах комисс нь “Баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт”-аар хадгалах хугацаа нь дууссан, мэдээлэл лавлагаанд ашиглагдахгүй болсон баримтыг цаашид архивт хадгалах шаардлагагүй гэж үзэн 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Баян-Өлгий аймгийн “Суат” ХХК-ний уурийн зууханд, албаны 3131-БӨА ланд крузер машинаар зөөж нийт 377 ширхэг хадгаламж нэгжийг устгалд оруулав. Нийт 377 хадгаламжийн нэгж болон бүртгэлийн журналууд, 94250 гаруй хуудас бүхий материалыг тус тус устгалд оруулсан болно. 2021 оны устгалд оруулах хадгаламж нэгжүүдийг устгалд оруулж, дараагийн жил устгалд оруулах хадгаламжийн нэгжүүдийг түүвэрлэж жагсаалт гарган УБЕГазарт хүргүүлсэн болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/02 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ыг албан хаагчдад танилцуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мэдээллийн болон кибер орчны аюулгүй байдлыг хангах Улаанбаатар хотоос ирсэн ажлын хэсэг болон аймгийн Тагнуулын газартай хамтран тус хэлтсийн мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн. 2021 оны 4-р сарын 29-ны өдөр мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийхэд заагдсан ажлыг хийж хэрэгжүүлсэн талаарх тайланг аймгийн Тагнуулын газарт хүргүүлсэн.

УБЕГ-ын дэд даргын 2021 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 2/6415 тоот албан бичгээр ирүүлсэн “Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд иргэний улсын бүртгэлийн онлайн, офлайн системийг боловсруулж, хөгжүүлэлт хийх, хүлээлгэн өгөх, шинэ системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд УБЕГ-аас шинээр ирсэн тоног төхөөрөмжийг сумдын улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгөх, дадлагжуулах ажлыг зохион байгуулж, мэдээлэл технологийн ажилтнаар хичээл заалгаав. Иргэний улсын бүртгэлийн онлайн, офлайн системийг боловсруулах, хөгжүүлэх, шинэ системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд ирүүлсэн чиглэлийн дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулж 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн хэрэглэнд нэвтрүүлж эхэлсэн. Тус хэлтсийн улсын бүртгэгч нараас системийн асуудал буланд нийтдээ 103 төрлийн асуудал оруулснаас 24 алдаа засагдаж, 29 асуудал буцаагдаж, 50 асуудал хэвийн байна гэсэн гарч буй алдаа дутагдалыг тухай бүр шинэ системийн асуудалд бичиж засуулан ажиллаж байгаа болно.

УБЕГ-ын ИУБГ-ын даргын 2021 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн 4/7590 тоот албан бичгээр Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Улсын бүртгэлийн ерөнхий газар “Иргэний шилжин суурьших хөдөлгөөний цахим бүртгэл” хамтран хэрэгжүүлсэн ажлын хүрээнд улсын бүртгэлд бүртгүүлэх үйлчилгээний хөлс хураамжийг төлөх боломжгүй, оршин суух хаяггүй, бейн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлээгүй 25,45 насанд хүрсэн боловч хууль тогтоомжид заасан хугацаанд иргэний үнэмлэхээ солиулаагүй зорилтот бүлгийн иргэдийн судалгааг хавсралтын дагуу 20 иргэний нэрсийг гарган бүртгэлд хамруулан албан бичигт дурдагдсан хугацаанд хүргүүлэн, хэвлэгдэж ирсэн иргэний цахим үнэмлэхийг тухайн иргэдэд олгож ажиллав.

УБЕГ-ын ИУБГ-ын даргын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 4/7845 тоот албан бичгээр иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэлтэй, бүртгэлгүй шинээр олгогдсон хаягийн судалгаа гаргаж ирүүлэхээр ирсэн албан бичгийн дагуу тус аймгийн төвийн сум болон бусад сумдад ГХБХБГ-аас олгогдож байгаа шинэ хаягийн судалгааг хүснэгт загварын дагуу гаргаж 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр хүргүүлэн ажиллав.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн хэрэгжилтийг цаг алдалгүй хугацаанд биелүүлэн хүргүүлж ажиллав.

### **Гурав. Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн ажлын хүрээнд**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэд даргын 2021 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 8/699 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэл болон Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд тус аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй

сонгуулийн эрх бүхий иргэний тоог /Election.gasr.mn/ гаргаж, 2021 оны 2 дугаар сарын 4-ний өдөр хэлтсийн даргын албан бичгээр сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хүргүүлсэн.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлыг хангах, ерөнхий газрын төлөвлөгөөнд тусгасан ажлуудын бэлтгэл ажлыг хангах хүрээнд аймгийн ИТХ-ын тогтоолын дагуу 97 хэсэг байгуулсан хэсэгт тус бүрийн сонгогчийн тоо, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгогчдын нэрийн жагсаалтад бүрэн бүртгэсэн эсэх, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаарх гомдлыг тухай бүр цахим мэдээллийн сангаас тулган шалгаж иргэнтэй холбогдон хариу өгч шийдвэрлэх, сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, хүргүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих, сонгогч шилжих, сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах, санал авах байрны дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд хууль, эрх зүйн мэдлэг олгох, ирц бүртгэлийн программын дадлага олгох сургалтыг цаг тухай бүр хуулийн хугацаанд хэрэгжүүлж илтгэх хуудсаар ерөнхий хүргүүлж ажиллав. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутаг дахь Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанг хууль, эрх зүйн мэдээллээр хангах, тэдгээртэй гэрээ байгуулахад анхаарах асуудлаар сургалтыг өгөв.



УБЕГ-ын даргын баталсан хуваарь, сургалт зохион байгуулах төлөвлөгөөний дагуу сонгуулийн үеээр санал авах байрны дэргэд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны хууль, эрх зүйн мэдлэг олгох, ирц бүртгэлийн программын дадлага олгох сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдөр УБЕГ-ын дэд дарга Д.Долгормаа даргаар ахлуулсан сургалтын багтай хамтран амжилттай зохион байгуулж явуулсан.

Сонгуулийг зохион байгуулах аймгийн сонгуулийн хороо хорооны гишүүнээр тус хэлтсийн дарга Т.Заманбек томилогдон ажиллав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг төлөвлөгөөнд тусгасан ажлуудаа хуулийн хүрээнд амжилттай зохион байгуулж өндөрлүүлсэн болно.


## **Дөрөв. Бүртгэлийн үйл ажиллагаа**

### **4.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд :**

Тайлангийн хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/207 тоот тушаалаар шинээр батлагдсан “Иргэний улсын бүртгэл хөтлөх журам”-уудыг мөрдлөг болгон Иргэний улсын бүртгэлд 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт 23600 иргэн хамрагдсанаас:



Төрсний бүртгэл 2708, хүүхэд үрчлүүлсний 105, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 26, эцэг, /эх/ тогтоосны 9, гэрлэсний 770, гэрлэлт дуусгавар болсны 34, нас барсны 509, иргэний үнэмлэх олголтын 4669, үндэсний энгийн гадаад паспорт, түүнийг орлох бичиг баримтийн олголт 847, биеийн давхцахгүй өгөгдлийн 3878, шилжилт хөдөлгөөний бүртгэлд 1103, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд 1401 иргэн, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр гэрчилгээ дахин олголтыг 136, нөхөн бүртгэлд 126 иргэн тус тус бүртгэгдсэн байна. Нөхөн бүртгэлийн журмаар хамрагдсан 126 бүртгэлийг задалж үзвэл төрсний 44, үрчлэлтийн 1, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 1, гэрлэлтийн 77, нас баралтын 3 иргэн тус тус бүртгэгдсэн байна. /хүснэгт 1/



Шүүхийн шийдвэр болон хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр мэдээллийн санд бүртгэлгүй төрөлтийн 4, гэрлэлтийн 19, нас баралтын 2, архивын эх нотлох баримт болон лавлагааг үндэслэн төрөлтийн 40, гэрлэлтийн 58, үрчлэлтийн 1, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 1, нас барсны бүртгэл 1, нийт 101 иргэний мэдээллийг нөхөн бүртгэлийн журмаар бүртгэж маягтуудын “А” талыг УБЕГ-ын Иргэний улсын бүртгэлийн газарт тухай бүр хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан байна.

Төрөлт, гэрлэлтийн гэрчилгээгээ гээгдүүлсэн болон гэмтэсэн, засвар өөрчлөлтийн бүртгэлийн дахин олголтоор 136 иргэнд гэрчилгээ олгосон, Регистрийн дугаар, хүйс зөрүүтэй, шүүхийн шийдвэрээр нас тогтоолгосон, төрсөн, он, сар, өдөр давхцаж олгогдсон, огт бүртгэгдээгүй зэрэг нийт 44 иргэний регистрийн дугаарын бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэл хийж, гадаад иргэний гэр бүлийн бүртгэлд нийт 15 иргэн хамрагдсанаас төрсний 13, гэрлэлт дуусгавар болсны 1, үрчлэлтийн 1 бүртгэл тус тус бүртгэгдсэн байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, үйлчилгээний хүртээмжийг нь нэмэгдүүлэх, иргэдэд бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, хууль тогтоомжуудыг сурталчлан таниулах, иргэд үйлчлүүлэгчдэд эрх зүйн сургалт зохион байгуулах, улсын бүртгэгч нарын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хэлтсийн ажлын төлөвлөгөөнд ГХУСэргийлэх, сургалтын чиглэлээр хийх ажлыг тусгуулсан болно. Мөн тус аймагт улсын бүртгэгчгүй байсан Буянт, Ногооннуур сумдад улсын бүртгэгчээр түр орлон гүйцэтгэхээр томилогдсон С.Жаргалсайхан, Б.Жанар нарыг аймгийн төв Өлгий сумын улсын бүртгэгчид О.Алтанцэцэг, М.Роза нарт 7 хоног даадлага хийлгүүлэн ажлын хүлээлгэж өгсөн болно. Мөн улсын бүртгэгч нарын хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авилага ашиг сонирхолын зөрчил гаргахгүй байх үүднээс төвийн иргэний бүртгэл хариуцсан улсын бүртгэгч нарыг сэлгээн ажиллуулах хуваарыг хэлтсийн даргаар батлуулан хариуцлагыг өндөржүүлэн ажиллаж байна.

Цахим мэдээллийн санд эцэг эхийн мэдээлэл, ургийн овог ороогүй , үрчлэлтийн бүртгэл хүчингүй болгохоор нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 1401 хийж ИБЗ-1 маягтын хамт ажлын 5 хоног болгон нэгтгэн албан бичгээр ИУБГ-т хүргүүлэн мэдээллийн санд тусгуулан ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, архивын эх нотлох баримт, лавлагааг үндэслэн нөхөн бүртгэлээр 25 бүртгэлийг хийж мэдээллийн санд тусгуулахаар маягтын А талыг ИУБГ-т хүргүүлэн мэдээллийн санд тусгуулсан.

Хурууны хээ давхардсан төлөвтэй иргэний үнэмлэх хэвлэгдээгүй, яс үндэс буруу, мэдээлийн санд овог, эцэг, эхийн нэр, нэр зөрүүтэй гэсэн шалтгаантай байсан 818 иргэнийг шалгаж хяналтын улсын байцаагчаар 27 удаа дүгнэлт гаргуулан зөрчлийг арилгуулж, иргэний үнэмлэх олгох арга хэмжээг авч ажилласан.

Тайлант хугацаанд нийт 7279 лавлагаа олгосон ба иргэнд 6104 лавлагаа, албан хэрэгцээнд 756 лавлагаа, хууль хяналтын байгуулагаад албан тоотоор 419 лавлагааг тус тус олгосон болно.

Мэдээллийн шуурхай байдлыг хангах, мэдээлэл солилцох үүднээс телеграммаар ирсэн мэдээлэл, үүрэг чиглэлийг сумын улсын бүртгэгч нарт шуурхай хүргэн ажиллаж байна.


Сумдын улсын бүртгэгчийн өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, цаашид алдаа дутагдал гаргахгүй байх, бүртгэлийн үнэн зөв байдлыг хангах, төрийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй үзүүлэх зорилгоор ИУБГ-аас өгсөн чиглэлийн дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтөлдөг улсын бүртгэгч нарт иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийг харах эрхийг нээлгэн ажиллаж байна. Мөн Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд заасны дагуу шилжилт хөдөлгөөний бүртгэлийг 4 дүгээр сарын 9-ний өдөр зогсоож илтгэх хуудсаар ИУБГ-т хүргүүлсэн болно.

#### **4.2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:**

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль журмын дагуу явуулж 2021 оны байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

Тайлангийн хугацаанд үйлчилгээний хураамжийн орлого 123.8 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхээ худалдсанаас оруулсан татварын орлого 206.5 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 4.0 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт оруулсан байна.

Мэдүүлэг, анхны бүртгэл, гэрээ хэлцэл



Нийтдээ 13253 мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэснээс газар өмчлөх эрхийн бүртгэл 4669, газар эзэмших, ашиглах эрхийн бүртгэл 1866, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл 6718 тус тус бүртгэж эрхийг нь баталгаажуулсан байна.

Тайлангийн хугацаанд нийтдээ 1461 өмчлөх эрх шилжих гэрээ бүртгэж баталгаажуулсан бөгөөд худалдах худалдан авах гэрээ 889, бэлэглэх гэрээ 203, арилжих гэрээ 2, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх бүртгэл 161, шүүхийн шийдвэрээр 4, албадан дуудлага худалдаагаар 3, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 199 бүртгэл бүртгэж баталгаажуулсан байна.

Үйлчилгээний хураамж, Улсын тэмдэгтийн хураамж, 2%-ийн татвар.



Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд олгогдож буй 3 хувийн хүүтэй зээлтэй ажлын байрыг дэмжих зээл, ипотекийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгосноор Барьцааны гэрээ нийтдээ 7461 барьцааны гэрээ бүртгэсэн ба барьцаалбартай барьцааны гэрээ 1678, барьцаалбаргүй барьцааны гэрээ 1984, барьцаалбартай барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 223, барьцаалбаргүй барьцааны гэрээнд өөрчлөлт оруулах 441, барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэл 3135 бүртгэж баталгаажуулсан байна. Өмнөх мөн үетэй харьцуулахад барьцааны гэрээний бүртгэл 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Тайлангийн хугацаанд 1116 бүртгэлд өөрчлөлт оруулсан бөгөөд үүнээс үрэгдүүлсэн гэрчилгээг нөхөн олгох 44, гэмтээсэн гэрчилгээг дахин олгох 1, эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 1024, өмчлөгчийн хүсэлтээр нэмэлт өөрчлөлт залруулга хийх бүртгэл 44, түрээсийн гэрээ 3 тус тус бүртгэж баталгаажуулсан байна. Мөн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн талаар иргэн, хуулийн этгээдэд 59 лавлагаа, 84 хуулбар олгож, 114 хувийн хувийн хэргийг хаасан байна.

Хууль хяналтын байгууллагаас гаргасан албан хүсэлтийн дагуу эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн талаарх 191 лавлагаа мэдээлэлийг албан тоотоор хүргүүлэн ажиллаж, 6 эрхийн улсын бүртгэлд тусгай тэмдэглэл хийж, эрх бүхий этгээдийн шийдвэр, хүсэлтийг хувийн хэрэгт нь хавсаргаж цахимжуулсан болно.

Хяналт шалгалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн улсын байцаагчийн 02 дугаар албан шаардлагын дагуу илэрсэн зөрчлүүд болох 2 дугаар

хавсралтанд дурдсан 86 жагсаалт буюу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх үед бүртгэлийг мэдээллийн цахим санд зөрүүтэй, дутуу, буруу бүртгэсэн зөрчлийг мэдээллийн цахим сангаас нэг бүрчлэн шалгаж, эрхийн улсын бүртгэлд мэдээллийг зөвтгүүлэхээр хяналтын улсын байцаагчийн 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 1625 тоот дүгнэлтээр мэдээллийн санд өөрчлөлт оруулан зөрчлийг бүрэн арилгасан.

Улсын байцаагчийн албан шаардлагын 4 дүгээр хавсралтанд дурдсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэх үед нэгж талбарын дугаарын тусгаагүй 33 зөрчлийг мэдээллийн цахим санд нэг бүрчлэн шалгаж, эрхийн улсын бүртгэлд нэгж талбарын дугаарыг тусгуулахаар хяналтын улсын байцаагчийн 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 1588 тоот дүгнэлтийн дагуу мэдээллийн санд нэгж талбарын дугаарыг тусгаж зөрчлийг бүрэн арилгасан.

Улсын байцаагчийн албан шаардлагын 5 дугаар хавсралтанд дурдсан Худалдах худалдан авах гэрээний үнийн дүнгээр үл хөдлөх хөрөнгийн үнэ өөрчлөөгүй 638 бүртгэлийг нэг бүрчлэн мэдээллийн цахим сангаас шалгаж үзэхэд 359 бүртгэлийг үнэн зөв бүртгэсэн байх ба 259 бүртгэлд үнэ өөрчлөөгүй зөрчил илэрсэн. Худалдах, худалдан авах гэрээний үнийн дүнгээр үл хөдлөх хөрөнгийн үнээр өөрчлөлт оруулахаар хяналтын улсын байцаагчийн 2021 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 1587 тоот дүгнэлт дагуу мэдээллийн санд өөрчлөлт оруулан зөрчлийг бүрэн арилгасан бол цаасан эх нотлох баримтыг цахимжуулах явцад цахим мэдээллийн сан /ePRS/-д үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалсан барьцааны /ипотек/ гэрээний нэг тал болох барьцаалагч талын мэдээлэлд өмчлөгчийн мэдээллийг эсвэл барьцаалагч хуулийн этгээдээс гадна давхар өмчлөгч иргэний мэдээллийг оруулж цахимжуулсан алдаа гарсан байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасны дагуу эрхийн улсын бүртгэлд тусгах мэдээллийг зарлуулах, мэдээллийн санд өөрчлөлт оруулахаар хяналтын улсын байцаагчаар 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр 1118 тоот дүгнэлт гаргуулан [edkhourungu@burtgel.gov.mn](mailto:edkhourungu@burtgel.gov.mn) цахим хаягаар болон 01/425 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

Цаашид Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчдийг хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, бүртгэлийг үнэн зөв хөтлөх болон цахим системийн боловсруулалтанд анхаарч ажиллах талаар хэлстийн хурлаар анхааруулан ажиллаж байгаа бөгөөд эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой ЭХЭУБГазраас ирсэн чиглэлийг тухай бүр улсын бүртгэгчдэд танилцуулан бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Мөн иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээнд салбар дундын хууль эрх зүйд холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэхэд хамтран ажиллах талаар наториатын үүргийг орлон гүйцэтгэдэг Сумдын Засаг даргын тамгын газрын дарга нар болон Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албан бичиг хүргүүлэн ажилласан.

#### **4.3. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:**

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 580 бүртгэл хийсэн болно.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 837 бүртгэл хийсэн болно. Үүнд: шинээр бүртгэсэн ТБАГУТҮГ 2, ХХК 122, НҮТББ 15, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага 2, Нөхөрлөл 2, Шашны байгууллага 28, Хоршоо 3, Нэмэлт өөрчлөлтийн бүртгэл 382, дахин гэрчилгээ 66, оноосон нэрийн баталгаажуулалт 215 болно. Тамга тэмдгийн хяналтын дугаар олголт 213, ашиглалтын шаардлага хангаагүйн улмаас дахин тэмдэг хийлгүүлэх хүсэлтээр 58 тэмдэг хурааж авсан. 1 НҮТББ-ыг өөрийн хүсэлтээр татан буулгасан бүртгэлд бүртгэсэн.

МЗЭ-ийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөл, Ард лизинг ХХК, Гялс кредит ББСБ-ын Баян-Өлгий аймаг дахь салбарыг зохих журмын дагуу бүртгэж салбарын гэрчилгээ олгож, мөн тус аймагт үйл ажиллагаа явуулж буй 3 салбарт тамга, тэмдгийн хяналтын дугаарыг зохих журмын олгож ажилласан.


Хуулийн этгээдийн цахим мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдэд 152 дүрмийн хуулбар, 86 лавлагаа гаргаж өгсөн байна.

Тайлант хугацаанд шинээр болон нэмэлт өөрчлөлтөөр бүртгэсэн 837 бүртгэлийн бүрдүүлбэр бичиг баримтыг зохих журмын дагуу цахимжуулж архивт хугацаанд нь шилжүүлэн ажиллав.

Шүүхийн байгууллагад хянагдаж буй 8 хэрэгт холбоотой хуулийн этгээдийн талаарх мэдээлэл, нотлох баримтын хуулбарыг зохих журмын дагуу гаргаж өгч ажилласан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2021 оны эхний 11 сарын тоон мэдээг хугацаанд үнэн зөв гаргаж, ХЭУБГ-т хүргүүлж ажиллав. 2020 оны эхний 11 сард шинээр 104 хуулийн этгээд бүртгэгдсэн бол 2021 оны мөн үед 174 хуулийн этгээд шинээр бүртгэгдсэнээр шинэ бүртгэл 1,6 дахин нэмэгдсэн байна. Хуулийн этгээдийн мэдээлэл оруулсан өөрчлөлт 2020 онд 144 байсан бол 2021 оны эхний 11 сард 215 болж 1,4 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 92 албан тоот, 7 өргөдлийг хүлээн авч хариутай албан тоот, өргөдөлд хугацаанд нь хариу хүргүүлж ажилласан болно.



Тус аймагт Шашны байгууллага шинээр байгуулж, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн иргэдийн хүсэлтийг хянан аймгийн ИТХ-д санал оруулах ажлын хэсэгт орж ажиллав. Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу тус



аймагт шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудад шалгалт хийх ажлын хэсэгт орж, Өлгий сумын төвд үйл ажиллагаа явуулж буй мечетүүд болон Пазилет энэрэл, Нур шапагат, Оюунлаг алхам, Дунд азийн залуучуудын төв зэрэг төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, бүртгэлийн чиглэлээр холбогдох зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна. Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн тооллого 2021 оны 11 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 01-ны өдөр хүртэл зохион байгуулагдсантай холбоотой зарим аж ахуйн нэгжтэй холбоотой мэдээллийг аймгийн Статистикийн хэлтэст гаргаж өгч хамтран ажилласан болно. Сумдын улсын бүртгэгч нартай хамтран эхний ээлжинд тухайн сумын төрийн байгууллагууд болох ЗДТГ, ИТХ, Өрхийн эрүүл мэндийн төв, Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг байгууллагуудын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд үзлэг хийлгэж, одоогийн удирдлагууд нь улсын бүртгэлд бүртгэгдсэн эсэхийг шалгуулж зөрчилтэй бол зөрчлийг нэн даруй арилгуулах талаар хуулийн зөвлөгөө өгүүлж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шинэчилсэн бүртгэлд бүртгэгдээгүй 19 шашны байгууллагын холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу бүрдүүлэн авч хуулийн этгээдийн цахим санд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгон, бүрдүүлбэрийг цахимжуулж хувийн хэргийг архивт шилжүүлэн өгсөн. Тус аймагт шашны үйл ажиллагаа явуулахаар 2005, 2006 онд ХЗДХЯ-нд бүртгэгдсэн боловч шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй байгаа Рашдэчинлин хийд, Раашгэмпиллин хийд, Дашчойнхорлин хүрээ, Инабат мечеть, Сагид бин зайд, Ах мешит зэрэг шашны байгууллагуудын үүсгэн байгуулагчдад шинэчилсэн бүртгэлд хамрагдахыг биечлэн болон утсаар мэдэгдэж ажилласан.

Өнөөдрийн байдлаар хуулийн этгээдийн хувийн хэргийн тооллого хийж байгаа бөгөөд хувийн хэргийг нэг бүрчилэн тоолох явцад цөөнгүй хуулийн этгээд нь анх байгуулагдсан цагаас хойш ямар ч нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хийлгээгүй байгаа байдал анзаарагдаж байна. Энэ нь тухайн хуулийн этгээд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Ийм хуулийн этгээдийн судалгааг гаргаж татварын сантай тулгалт хийх шаардлагатай гэж үзэж байгаа бөгөөд 2022 онд энэ чиглэлээр тодорхой ажил зохион байгуулахаар төлөвлөж байна.

#### **4.4. Хяналт, шалгалтын үйл ажиллагаа**

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18.7.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.9, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/289 дугаар тушаалаар баталсан Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасныг тус тус үндэслэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхдөө холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, улсын бүртгэлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэн, улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг илрүүлэн түүнийг таслан зогсоох, илэрсэн зөрчлийг арилгуулан Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, иргэн хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж, засвар өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж,

хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийн хангуулж ажиллаж байна.

2021 оны Хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, архивын үйл ажиллагаанд 16 удаа төлөвлөгөөт 12 удаа гүйцэтгэлийн шалгалтыг 20393 бүртгэлд хийсэн байна. Шалгалтын явцад гарсан зөрчлийг таслан зогсоох, арилгуулах арга хэмжээг бүрэн авч 16 албан шаардлага хүргүүлэн зөрчлийг тухай бүр арилгасан.

Иргэдээс улсын бүртгэлийн зөрчил арилгуулах болон хяналтын байцаагчийн дүгнэлт гаруулахаар 285 өргөдөл хүлээн авч 12642 иргэн, хуулийн этгээдэд холбогдох 233 дүгнэлт гаргаж, хууль журмын дагуу хянаж шийдвэр гаргаж, хариу мэдэгдсэн болно. Үүнд: Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 124 дүгнэлт гаргаж нийт 1401 иргэний бүртгэлийн зөрчлийг арилгасан, бүртгэлийн үнэн бодит нөхцөл байдлыг тогтоосон байна. Үүнд Бүртгэл хүчингүй болгох тухай 30, бүртгэх тухай 20, зөрчил арилгах тухай 50, регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай 31, Регистрийн дугаар хүчингүй болгох тухай 3, регистрийн дугаар сэргээх тухай 1, бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 21 тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нийт 100 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл хүсэлт, бүртгэлийн зөрчлийн дагуу нийт 11391 эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой бүртгэлд дүгнэлт гаргаж хуулийн дагуу хянан шийдвэрлэж, зөрчлийг арилгасан болно. Үүнд. Бүртгэл хүчингүй болгох тухай 30, бүртгэл хийх тухай 4, зөрчил арилгах тухай 24, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 52 бүртгэлд тус тус дүгнэлт гаргаж 11391 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт 19 дүгнэлт гаргасан байна. Үүнд Бүртгэл хүчингүй болгох тухай 2, бүртгэл хийх тухай 0, зөрчил арилгах тухай 9, нэмэлт өөрчлөлт оруулах тухай 7, Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүйд тооцох, дахин олгох тухай 3 нийт 25 хуулийн этгээдийн улсын бүртгэлийн бүртгэлийн зөрчлийг арилгасан байна. Тамга, тэмдгийн хяналтын дугаарыг шинээр олгох 4, дахин олгох 15 бүртгэлд тус тус хяналт тавьсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Улсын ерөнхий байцаагчийн 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн “Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь хэлтсээс иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын удирдамж, УБЕГ-ын Хяналт шалгалтын газрын 2021 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн хяналт шалгалт хийх, зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагаанд ирүүлсэн чиглэлийн хүрээнд 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийг дуусталх хугацаанд тус аймгийн 13 сум, 1 тосгоны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй барьцаалан зээлдүүлэх газар, хүнсний дэлгүүр, ТҮЦ, зочид буудал, бусад үйлчилгээний газруудаас иргэдэд үйлчилгээ үзүүлэхдээ иргэний үнэмлэх, энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ хууль бусаар барьцаалсан үйлдэл, энгийн гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээ хууль бусаар барьцаалсан үйлдэл байгаа эсэхийг шалгаж, зөрчилтэй баримт бичгийг хураан авч, зөрчил шалган шийдвэрлэх, зөрчлийн шинжгүй иргэд хуулийн этгээдэд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган

шийдвэрлэх тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, заавар, журмыг танилцуулах, мэдээлэл өгөх арга хэмжээ авч ажиллав.

Уг шалгалтад аймгийн нутаг дэвсгэрт 13 сум 1 тосгоны баг тус бүрд үйл ажиллагаа явуулдаг нийт 354 гаруй аж ахуйн нэгж, хүнсний дэлгүүр, эмийн сан, барьцаалан зээлдүүлэх газар, ТҮЦ, зочид буудал, рестораны үйл ажиллагааг шалгах аар төлөвлөсөн ч зарим газрын үйл ажиллагаа аймгийн Онцгой комиссын шийдвэрээр зогссон байх тул шалгах боломжгүй, зарим нь үйл ажиллагаа түр зогсоосон байсан. Харин аймгийн нутаг дэвсгэрт явуулдаг үйл ажиллагаа явуулж буй барьцаалан зээлдүүлэх газар, хүнсний дэлгүүр, ТҮЦ, зочид буудал, бусад үйлчилгээний газрууд зэрэг нийт 296 үйлчилгээний газар, аж ахуйн нэгж, хувь хүний үйлчилгээний газруудад шалгаж тухай бүр илтгэх хуудсыг хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй, тогтоосон хууль, журам зөрчсөн, үндэсний энгийн гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх үрэгдүүлсэн, гэмтээсэн, иргэний үнэмлэх болон үндэсний энгийн гадаад паспорт, иргэний гэр бүлийн байдлын баримт бичиг олгох, эзэмших, ашиглах, хадгалах, шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам зөрчсөн, иргэн хуулийн этгээд тамга, тэмдэг үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах журам зөрчсөн үндэслэлээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.20-д “улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 8.2 дугаар зүйлийн 2, 6, 7, 10.20 дугаар зүйлийн 1, 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 15.23 дугаар зүйлийн 1.1, 15.24 дүгээр зүйлийн 1, 2, 4 дэх хэсэгт заасан зөрчлийг гаргаж зөрчсөн 240 зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэн төсөвт нийт 6 430 000 төгрөг оруулсан байна. Үүнд Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 1 дэх заалт тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй 63 зөрчилд 1 260 000 төгрөгний торгууль, Зөрчдийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 4 дэх заасан Иргэний үнэмлэхээ гээгдүүлж иргэний улсын бүртгэлийн талаар тогтоосон журам зөрчсөн 22 зөрчилд 660.000 төгрөг торгууль, Зөрчдийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйлийн 2 дах заалт Иргэний үнэмлэх, гадаад паспорт, улсын бүртгэлийн гэрчилгээг барьцаалсан, барьцаалуулсан, зориуд гэмтээсэн 11 зөрчилд 250000 төгрөг торгууль, Зөрчдийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 1.1 дэх төрийн Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй зөрчил 1, мөн зүйлийн 1.2-т заасан улсын бүртгэлд үнэн зөв мэдүүлээгүй зөрчил 2 буюу 150 000 төгрөг торгууль, Зөрчдийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1-т заасан Тамга, тэмдэг үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах журам зөрчсөн 2 зөрчилд 50 000 төгрөг торгууль эзэлж байна. Хоёр зөрчлийн хэрэг хянан шалгав.

Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах тогтоол 39 гаргасан болно.

Зөрчил шалган шийдвэрлэсэн тухай тайлан мэдээг хуулийн тогтоосон хугацаанд гаргаж аймгийн прокурорын газарт хүргүүлж байна. Шалгасан зөрчлийн хэрэг, хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн зөрчлийг хуульд заасан хугацаанд шилжүүлж, тогтмол хянуулж байна. Мөн Аймгийн прокурорын

байгууллагатай хамтран ажиллах хүрээнд зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ байнга авч хэрэгжүүлж, судалгаа гарган ажиллаж байна.

Зөрчил шалган шийдвэрлэсэн тухай холбогдох 11 боть, иргэний өргөдөл, гомдол хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэсэн дүгнэлтийн 6 боть болгон хэрэг материалыг хууль журмын дагуу 250 хуудас бүхий нэгж үүсгээд байна.

### **Тав. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа**

2021 оны байдлаар иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн чиглэлээр ИУБ-11 төрөлт-2610, ИУБ-12 үрчлэлт-97, ИУБ-13 овог эцэг-эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл-22, ИУБ-14 эцэг тогтоолт- 8, ИУБ-15 гэрлэлтийн бүртгэл-691, ИУБ-16 гэрлэлт цуцалсаны бүртгэл-29, ИУБ-18 нас баралт-486, аймаг нийслэл рүү шилжин ирсэн-563, ИБЗ-1 мэдээлийн санд нөхөн бүртгэлд оруулах-126, ИУБ-31 Биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл-3125 буюу нийт 7757 маягтуудыг журмын дагуу хүлээн авч баримтыг хувийн хэрэгт баяжилт хийсэн болно. Иргэний 8-н төрлийн бүрдүүлбэр, гадаад паспорт мэдүүлэг 214 гаруй хадгаламж нэгж хүлээн авсан болно.

Хууль хяналтын байгууллагуудаас нийт 71 ширхэг албан тоотыг хүлээн авч холбогдох нотлох маягтуудыг хуулбарлан хүргүүлэв.

Регистерийн дугаар буруу, хүйс зөрүүтэй, ИУБ маягт нөхүүлэх МҮ-санд ороогүй, нас тогтоолгох, төрөлт тогтоох, нас баралт тогтоох, шүүхийн журмаар гэрлэлт цуцлалтын бүртгэлийн зөрчлийг арилгахын тулд нийт 266 иргэний хувийн хэргийг Архивын фондоос захиалгын хуудсаар бүртгэл хөтөлж Улсын бүртгэгч, Хяналтын улсын байцаагч нарт гаргаж өгөх хүлээн авч буцаан байрлуулан ажиллав.

Иргэний бичиг баримтын архивт 2010- 2016 онуудаад бусад аймгаас шилжин ирсэн иргэдийн ХААТР маягтийг “**түр сан**” гэж 40 гаруй хайрцаг ба нийт 210000 гаруй маягтыг үүсгэсэн байна. Үүнийг мэдээлийн сангаас нэг бүрчлэн шалгаж нас барсан, харьяатаас гарсан, тодорхойгүй /хаяггүй, мэдээлийн санд мэдээлэл нь байхгүй/ гэж ялгаж баяжилт хийж байршуулсан ба шилжин явсан иргэдийг тухайн аймаг руу жагсаалтаар хүргүүлж дуусгасан болно.



Хэлтсийн даргаас өгсөн үүрэг даалгавар болон төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд тус хэлтсийн иргэний бичиг баримтын архивт тооллого явуулах хуваарыг 2021.09.02-ны өдөр хэлтсийн даргаар батлуулж, тооллогын ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс эхэлж 2021 оны 11 дүгээр сарын 03-нд хийж дуусгасан болно. Сумдын бүртгэгч нарыг ажлын өдрийн 3,4,5 дахь өдрүүдэд архивт ажиллуулан өөр өөрсдийн сумдын хувийн хэргийг цэгцлүүлж тооллого хийлгүүлэв.

Хадгалах нэгжийн хугацаа дууссан бичиг баримтын тоог гарган УБЕГ-ын бичиг баримт нягтлан шалгах ажлын комисст хүргүүлэн, устгах баримт бичгийн жагсаалт ирүүлсэний дараа маягт болон дагалдах хуудасуудыг устгалд оруулсан.

Тайлант жилийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт нийт 3110 хувийн хэргийг шинээр архивт хүлээж авч шинээр нээсэн хувийн хэрэг бүртгэх маягт дэвтэрт бүртгэж улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу хаяглаж архивт байршуулсан болно.

Үүнд: газар өмчлөлийн анхны бүртгэл 322, газар эзэмших 1965, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн анхны бүртгэл 823 ,ашиглах эрхийн 2 хувийн хэрэг орсон байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар бүртгэл нь хүчингүй болж хаагдсан 111 хувийн хэрэг байна.

Мөн улсын бүртгэгч нарын өдөр тутам хүлээж авсан нэмэлт өөрчлөлт, худалдах худалдан авах гэрээ, бэлэглэх гэрээ, өв залгамжлах гэрээ , барьцааны гэрээ, лавлагаа, хуулбар зэрэг нийт 12999 гаруй нотлох баримтуудыг архивт хүлээж авч хувийн хэргийн байжилтыг цаг тухайд нь хийж байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивт 32291 хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүний : 14862 нь газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, 12717 нь газар өмчлөл, үлдсэн 4877 газар эзэмших эрхийн бүртгэл, 6 нь ашиглах эрхийн бүртгэлийн хувийн хэрэг байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд тусгасны дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт хувийн хэргийн тооллогыг 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр эхүүлж 2021 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр буюу 15 хоногийн хугацаанд хууль журмын дагуу хийж гүйцэтгэлээ.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэгт тооллогыг хувийн хэрэг дэхь эрхийн улсын бүртгэлийн нотлох баримт цахимжсан эсэх, алгассан дугаар байгаа эсэх, бүртгэлийн дүн тоотой тохирч байгаа эсэхтэй тулган шалгаж, хаасан хувийн хэргийн тоо, бүртгэлийн тоо, хуудасны тоог хувийн хэрэг тус бүрээр гаргаж тооллогоо хийлээ.

Нийт 27497 /ү14871, г12626/ хувийн хэрэгт тооллого хийсэн бөгөөд үүнээс бүртгэлийн тоо 78085 хуудасны тоо 867052 хаасан хувийн хэргийн тоо 187, алгассан дугаарын тоо 2 тус тус тогтоогдов. Сэлбэн засварлах, бичвэр тодруулах, гэмтсэн, ариутгах, үдэж хавтаслах, техникийн боловсруулалт хийх хувийн хэрэг гараагүй болно.

Мөн тавиурт байрласан хувийн хэрэг дараалал, байрлал алдагдаагүй, цахижуулаагүй хувийн хэрэг гараагүй болно.

Газар эзэмших, ашиглах эрхийн дугаарыг 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр хүртэл дундын мэдээллийн сангаас 4877 “Э, А” дугаарыг хуулийн хугацаанд түргэн шуурхай илгээж 18 хадгалжийн нэгж, газрын дугаарыг автоматаар



олгогдсон системээс газар эзэмших, ашиглах эрхийн хуудсыг хэвлэн дугаарын дараалалын дагуу 2 хадгаламжийн нэгж тус тус үүсгэн архивт хууль журмын дагуу хадгалагдаж байна.

Мөн БНШК-ын хурлаар хэлэлцэж устгуулах цахимжуулалтын үеэр тусгаарласан 200.0 мянган бүртгэлийн баримт бичиг архивт хадгалагдаж байгаа болно.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн бүртгэлийн 174 анхны бүртгэлийн хувийн хэргийг архивт хүлээж авч улсын бүртгэлийн дугаарын дэс дараалалын дагуу байршуулсан болно. Хуулийн этгээдийн улсын бүртгэгчид бүтэн жилийн хугацаанд 676 гаруй хувийн хэргийн баяжилтыг хүлээн авч цаг тухайд нь зохих журамын дагуу байршуулсан болно.

Өнөөдрийн байдлаар тус хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэлийн архивт нийт 2251 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Хураагдаж хүчингүй болсон 50 хуулийн этгээдийн хуучирч гэмтсэн тамга тэмдгийг журмын дагуу устгалд оруулсан болно.

### **Зургаа. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэх ажлын хүрээнд**

Хэлтсийн үйл ажиллагаа, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар санал, гомдол, хүсэлт хүлээн авах хайрцаг ажиллуулж ирсэн ба санал хүсэлт, мэдээллийг төрөлжүүлэн дүгнэж, тэдгээрийн мөрөөр авах арга хэмжээг зохион байгуулж байна. Өдөр тутмын үйл ажиллагаа болон улсын бүртгэлийн үйлчилгээ, зан харилцааны асуудлаарх иргэдийн өргөдөл, гомдол санал хүсэлтийг тухай бүр хэлтсийн дарга биечлэн хүлээн авч шийдвэрлэн, иргэдэд ойлгомжгүй байгаа асуудлыг Тасгийн дарга нараар тайлбарлуулан иргэдэд үйлчилж байна.

Авлига, ашиг сонирхол зөрчлийн талаар мэдээлэл ирээгүй байна.

Албан хэрэг хөтлөлтийн АВЛЕ програмд ирсэн, явсан бичиг болон өргөдөл, гомдлыг бүрэн цахимжуулан оруулж ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд /2021.12.02-ны өдрийн байдлаар/ хууль хяналтын болон бусад байгууллагуудаас 1295 албан бичиг хүлээн авсан байх ба нийтдээ 1622 албан бичиг гадагш явуулсны 1030 нь хууль, хяналтын байгууллага болон бусад байгууллагад хүргүүлсэн хариутай албан бичиг болно.

Мөн хэлтсийн даргын “А” тушаал 15, “Б” тушаал 4, нийт 19 тушаалыг гарган холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Оны эхнээс /2021.12.02/ иргэдээс нийт 222 өргөдөл хүлээн авч, холбогдох албан хаагч бүрт танилцуулан хувиарлан хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлсэн.

Үүнээс: Захиргаа удирдлагад /хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, эд материал, санхүүгийн дэмжлэгэ, албан хаагчдын чөлөө хүссэн г.м/ 21 өргөдөл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 12, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 13 өргөдөл ирсэн байх ба Иргэний бүртгэл болон Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргахтай холбоотой /үрчлэлт, төрөлт, нас баралт, гэрлэлт, гэрлэлт дуусгавар болсоныг бүртгүүлэх мөн регистрийн дугаар зөвөтгөх, гэрчилгээ дахин олгох, тодорхойлолт, лавлагаа олгох/ 176 байна.

2021 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар нийт 222 иргэний өргөдлөөс 220 өргөдлийг шийдвэрлэж, бусад байгууллагад шилжүүлсэн 0, хугацаа хэтрүүлж

шийдвэрлэсэн 0, хугацаа болоогүй 2 иргэний өргөдөл хяналтад байна. Мөн шийдвэрлэлтийн хувь 99.1%-тай байна.

Иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал иргэний бүртгэлийн чиглэлээр иргэний баримт бичгийн зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол ихэнх хувийг эзэлж байгаа ба иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж байгаа болно. Мөн иргэдийн өргөдөл, гомдлыг Хэлтсийн 70427810, 70427766 дугаарын утсаар авч ажиллаж байна.


2021 оны хагас жилийн байдлаар хэлтсийн үйл ажиллагааны явцад албан хэрэг хөтлөлтийн байнга хадгалах баримт 18 хадгаламжийн нэгж үүсгэж архивласан.

Өргөдөл гомдлын мэдээг загвар хүснэгт дагуу гаргаж, улирлын сүүлийн сарын 15-ны дотор УБЕГ-ын Тамгын газрын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэнд баталгаажуулан хүргүүлж байна.

Мөн хэлтсийн цахим хуудасны өргөдөл, гомдлын цонхонд тогтмол байршуулж байгаа болно.

Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах талаарх албан даалгаврыг ажилтнууддаа танилцуулан, хэлтсийн ажилтнуудын цагийн бүртгэлд тавих хяналтыг сайжруулан, өглөө болгон цагийн бүртгэлтэй танилцаж, чиглэл өгч ажилласан. Сумдын анхан шатны бүртгэгчдийн цаг ашиглалтын байдалд сумын Засаг даргын тамгын газартай хамтран хяналт тавин ажиллаж байна.

#### **Өргөдөл, гомдлын тоон үзүүлэлт графикаар:**



#### **Долоо. Нэгжийн ил тод байдлын тайлан / Мэдээллийн технологи, программ хангамжийн хүрээнд /**

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг”, Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Тус хэлтсийн цахим хуудас нь <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/> гэсэн хаягтай.

Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааг олон нийтэд түгээх зорилгоор хийсэн ажлын талаарх мэдээллийг фото зургийн хамт цахим хуудааст болон олон нийтийн социал сүлжээ буюу <https://www.facebook.com/bayanulgii.burtgel> фэйсбук

пэйж хуудсаар давхар түгээж ажиллаж байна. Үүнээс гадна УБЕГ-аас гаргасан аливаа шторк, мэдээллүүд, цахимаар бүртгэлийн үйлчилгээ авах зэрэг мэдээллийг тухай бүр байршуулан шэйр хийж байна. Өнөөдрийн байдлаар 2655 дагагчтай болсон байна. 2021 онд социал хуудсаар дамжуулан 31 иргэн мессэж илгээж бүртгэлийн талаар мэдээлэл авсан байна.

Цахим хуудасны танилцуулга цонхонд нэгжийн бүтэц, албан хаагчдын мэдээлэл, ил тод цонхонд шилэн данс, хурал, сургалт, семинарын зар, улирал, жилийн тайлан, хэрэглэгч танд цонхонд түгээмэл асуулт хариулт, нээлттэй ажлын байрны зар, өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал, сар бүрийн тоон мэдээ, холбоо барих цонхонд байгууллагын хаяг, байршил, ажиллах цагийн хуваарь, иргэдийг хүлээн авах цаг, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах утасны дугаар, шуудан хаяг зэргийг нээлттэй байршуулсан болно. <https://bayan-ulgii.burtgel.gov.mn/sar-buriin-toon-medeelel>

Нүүр хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, видео мэдээллүүд, аймгийн танилцуулга, түүх болон дурсгалт газрууд, фото зургийн цомог, мөн аймгийн далбаа, газрын зургийг бүрэн оруулсан. Баннер хэсэгт МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн нэрийн жагсаалттай танилцах холбоос, иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн лавлагаа, үйлчилгээ авах цахим систем, хуулийн этгээдийн оноосон нэр олголтын систем, авлигыг мэдээлэх 110 утас болон бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-1890 зэрэг баннерүүдийг байршуулсан.


Цахим хуудасны хөл хэсэгт бусад аймгуудын холбоос болон хэлтсийн Google тар дахь газрын зургийг харуулсан болно.

2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өдрөөс эхлэн дагаж мөрдөх Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай /Засгийн газрын 230 дугаар тогтоол/, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтын мэдээлэлтэй танилцах холбоос, заавар, сонгуультай холбоотой түгээмэл асуултыг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулав.

Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

№	Улсын бүртгэлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний нэр	Үйлчилгээний хөлсний хэмжээ (төгрөг)
Нэг. Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ		
1.1.	Төрсний бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох	Үнэ төлбөргүй
1.2.	Төрсний гэрчилгээ дахин олгох	10000 төгрөг
1.3.	Гэрлэсний бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох	2500 төгрөг
1.4.	Гэрлэсний гэрчилгээ дахин олгох	10000 төгрөг
1.5.	Гэрлэлт дуусгаар болсны бүртгэлд бүртгэх	2500 төгрөг
1.6.	Гэрлэлт сэргээсний бүртгэлд бүртгэх	2500 төгрөг
1.7.	Эцэг (эх) тогтоосны бүртгэлд бүртгэх	2500 төгрөг
1.8.	Урчилсний бүртгэлд бүртгэх	2500 төгрөг
1.9.	Овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэлд бүртгэх	2500 төгрөг
1.10.	Хүйс өөрчлөгдсөний бүртгэлд бүртгэх	2500 төгрөг
1.11.	Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийн бүртгэлд бүртгэх	Үнэ төлбөргүй
1.12.	Төрсний болон гэрлэсний гэрчилгээг сольж олгох	5000 төгрөг
1.13.	Нас барсны бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгох	Үнэ төлбөргүй
1.14.	Монгол Улсын иргэний үнэмлэх авч удаа олгох болон 25, 45 насанд сольж олгох	15000 төгрөг
1.15.	Монгол Улсын иргэний үнэмлэх дахин олгох	30000 төгрөг
1.16.	Үндэсний энгийн гадаад паспорт олгох (5, 10 жил)	27500 төгрөг (Үйлчилгээний хөлс-12500, бичилтийн үнэ-15000)
1.17.	Үндэсний энгийн гадаад паспорт дахин олгох (хуудас, хугацаа дууссан тохиолдолд)	27500 төгрөг (Үйлчилгээний хөлс-12500, бичилтийн үнэ-15000)
1.18.	Үндэсний энгийн гадаад паспорт дахин олгох (хавсан, үрэгдүүлсэн, гэмтээсэн тохиолдолд)	40000 төгрөг (Үйлчилгээний хөлс-25000, бичилтийн үнэ-15000)
1.19.	Үндэсний энгийн гадаад паспортыг гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан олгох	48500 төгрөг
1.20.	Хил орчмын нутагт зорчих нэг удаагийн үнэмлэх олгох	3000 төгрөг
1.21.	Хил орчмын нутагт зорчих олон удаагийн үнэмлэх олгох	10000 төгрөг
1.22.	Нийслэлээс аймагт, нэг аймагаас өөр аймагт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх	2500 төгрөг



2021

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ

Иргэн та

<http://election.burtgel.gov.mn/>  
 холбоосоор нэвтэрч Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн мэдээлэлтэй танилцах боломжтой.

Хэлтсийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг батлагдсан төсвийн хүрээнд хяналттай үр ашигтай, хэмнэлттэй байдлаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

2021 оны эхний 11 сарын байдлаар улсын төсвөөс 472.779.700 төгрөг, нэмэлт санхүүжилтээр сонгуулийн зардалд 91.137.000 төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 7.435.0000 төгрөг, нийт 571,351,700 төгрөгийн санхүүжилт авснаас 567.563.658 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан ба энэ нь нийт төсвийн 99.3% байна. Мөн тайлант хугацаанд 170.000.000 төгрөгийн орлогын төлөвлөгөөтэй байсанаас 207.398.528,05 төгрөгийн орлого оруулж, Сангийн Яам Улсын Төсөвт 205.478.939.72 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн болно. Орлогын төлөвлөгөөг 95%-иар биелүүлсэн болно. Сар бүрийн 2-ны өдрийн дотор төсвийн гүйцэтгэлийн тайлан ба өглөг авлага, нэр данс зөрүүгийн тайлан, санхүүгийн сарын мэдээг УБЕГ-т хүргүүлж ажиллаж байна. Үнэт цаасны зарцуулалтын тайлан болон үлдэгдлийн тайлан, иргэний үнэмлэхийн орлогын тайланг хугацаанд нь дээд газарт хүргүүлж байна. Одоогийн байдлаар тус хэлтэс нь ямар нэгэн өр авлагагүйгээр ажиллаж байгаа болно. Мөн түүнчлэн ХАОАТ болон НДШ-ийн тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хуулийн хугацаандаа хүргүүлсэн. Хэлтсийн 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгүүлж “Итгэл үзүүлэх” дүгнэлт авсан болно. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд холбогдох дансны мэдээллүүд болох тухай бүр оруулах 88 ш, сар бүр оруулах 33, улирал бүр оруулах 3, хагас жилээр оруулах 4, бүтэн жилээр оруулах 5 мэдээллүүдийг хуулинд заасан хугацаанд нь оруулж ажиллаж байна. Үнэт цаасны тооцоог сар болгон албан хаагч бүртэй хийж, үлдэгдэл үнэт цаасыг тулган ажилласан.

Хэлтсийн төсөв, санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангах, байгууллага, иргэдэд нээлттэй байлгах ажлын хүрээнд байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст 2021 оны төсөв болон орлого, зарлага, төсвийн байгууллагын санхүүжилтийн 1-11 дугаар сарын мэдээнүүдийг хуульд заасан хугацаанд шилэн дансанд байршуулсан. Мөн 2022 оны төсөв 2023-2025 оны төсвийн төсөөлөл, төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2020 оны биелэлтийг хүргүүлж, 91 хувиар дүнг баталгаажуулан дүгнүүлсэн ба 2021 оны аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны улсын тооллогод хамаарч холбогдох баримт, тооцоолуудыг хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллав. Санхүүгийн тайланг улирал, хагас жилээр гарган холбогдох газарт хүргүүлсэн. 11 сарын байдлаар Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас 28.146.000 төгрөгийн үнэт цаас бараа материал, хүлээн авч санхүүгийн тайландаа тусгасан болно. Хэлтсийн эд хөрөнгийн тооллогыг хэлтсийн даргын тушаалын дагуу хуулийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

### **Найм. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах /Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан байдал/**

Аймгийн ЗДТГ, болон бусад төрийн байгууллагатай хамтран ажиллаж, холбогдох тайлан мэдээг хүргүүлэн ажилласан ба төрийн болон хууль хяналтын байгууллагад лавлагаа мэдээллийг хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга Д.Бауыржанаар ахлуулсан баг өвөлжилтийн нөхцөл байдал болон Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж буй байдал, төрийн үйлчилгээний хүртээмжтэй танилцах зорилгоор

сумдад ажиллаж, ажлын хэсэгт тус хэлтсийн дарга Т.Заманбек орж ажилласан болно.



Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд тус хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга Д.Аманбек Улсын бүртгэлийн байгууллагад бүртгэгдэж байгаа үрчлэлтийн бүртгэл, олгож буй төрсний болон үрчилсний бүртгэлийн лавлагаатай холбоотой асуудлаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн удирдлага, албан хаагчидтай 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр уулзалт, ярилцлага зохион байгуулан ажиллаа.

Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөл Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2 удаа зохион байгуулсан ба тус шалгалтад орохоор бүртгүүлсэн иргэдийг Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлээр /хуруу хээ/ таниулан шалгалт өгөх эрхийг баталгаажуулан хамтран ажилласан болно.

2021 онд бүртгэлийн чиглэлээр, Ерөнхийлөгчийн сонгууль, шилжилт хөдөлгөөний бүртгэл болон цаг үеийн асуудлаар орон нутгийн радио, телевизд 10 удаа ярилцлага, мэдээ мэдээлэл өгч ажиллаа.

Газрын харилцаа, хот байгуулалтын газрын удирдлагуудтай төрийн албаны уялдаа холбоог сайжруулах, иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх үйлчилгээнд салбар дундын хууль эрх зүйд холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангаж төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх хамтарсан ажил хэргийн уулзалт зохион байгуулав.



Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний хүрээнд олгогдсон 3 хувийн хүүтэй ажлын байрыг дэмжих зээл, ипотекийн зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож байгаатай уялдан ипотекийн гэрээ болон өмнө бүртгүүлсэн гэрээний нэмэлт өөрчлөлтийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдуулан тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Арилжааны банкны төлөөллүүдтэй уулзалт хийж, хамтран ажиллахаар тохиролцов.



Аймгийн Засаг даргын Тамгын газраас санаачлан хэрэгжүүлж байгаа төрийн үйлчилгээний ХӨДӨЛГӨӨНТ БАЙР иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх ажлын хүрээнд тус аймгийн Бугат, Баяннуур, Алтанцөгц, Буянт, Алтай, Толбо, Улаанхус, Цэнгэл, Сагсай, Ногооннуур сумуудад болон Цагааннуур тосгон, Улаанбайшинт боомтын нийт 715 малчид, иргэдэд бүртгэлийн үйлчилгээг нэг цэгээс хүргэж ажиллав.



Сумдад ажиллах үеэр тус хэлтсийн албан хаагчид төрсний бүртгэлд шинээр төрсөн хүүхдийг бүртгэж төрсний гэрчилгээ, гэрлэсний бүртгэлд бүртгэж гэрлэсний гэрчилгээ, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн өмчлөх эрхийн гэрчилгээг дурсамжийн хамт ёслол төгөлдөр гардуулан ажиллав.



НҮБ-ын Шилжилт Хөдөлгөөний байгууллагын төслийн баг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Дэд сайдын хамт Баян-Өлгий аймаг дахь олон иргэдэд тулгарч буй иргэншилтэй холбоотой болон шилжин суурьших асуудлаар санал солилцож тус аймгийн тусгай хамгаалалтын газар нутагтай сумууд, Улаанбайшинт хилийн боомт, Увс аймгийн газар нутагт байрлах Хотгор баг зэрэг оршин суух газрын хаягаа нотлох баримт бичиг

- эд хөрөнгийн өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
- газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгогдохгүйгээс болоод шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдаж чадахгүй байгаа иргэдийн судалгааг гаргаж танилцуулан ажиллав.



Сар бүрийн 3-ны өдөр цусаа бэлэглэх өдөр болгон зарласны дагуу аймгийн цусны төвтэй хамтран 2 удаа албан хаагчид цусаа хандивлав. Тус хэлтсийн Улсын ахлах бүртгэгч Д. Аманбек, Улсын бүртгэгч М.Роза, Ахлах нягтлан бодогч А. Ертауке нар тогтмол цусаа бэлэглэдэг донор ажилчид болно.

Улс тунхагласны 97 жилийн ойн баярыг угтаж аймгийн ЗДТГ, АГХЗХГ /аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар /-тай хамтран 16 нас хүрч шинээр цахим үнэмлэхээ гардан авч буй 44 хүүхдэд, бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 81 жилийн ойг тохиолдуулан 21 хүүхдэд иргэний андгай өргүүлэн “Батламж” хадгалуулан цахим үнэмлэхийн ёслол төгөлдөр гардуулах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.




### **Ёс. Сургалт, үйл ажиллагаа тайлагнах ажлын хүрээнд**

Тайлант хугацаанд УБЕГ-аас болон хэлтсийн хэмжээнд зохион байгуулагдсан нийт 36 удаагийн танхимын болон онлайн сургалтын бэлтгэл ажлыг ханган ажилласан. Давхардсан тоогоор 621 хүн хамрагдав. Удирдлагын академээс зохион явуулсан богино хугацааны мэргэшүүлэх зайны сургалтанд 2 албан хаагч хамрагдаж үнэмлэх авсан болно. Тус аймгийн төрийн албан хаагчдад 2021 оны 2 дугаар сарын 01-19-ний өдрийн хооронд тусгай хөтөлбөрийн дагуу Удирдлагын академээс зохион байгуулсан Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа – 2050” сэдэвт богино хугацааны зайны сертификат олгох онлайн сургалтанд бүрэн хамрагдав.

Дотооддоо дараах сургалтуудыг зохион байгуулав.

- “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ын танилцуулга
- E-mongolia цахим хуудаснаас улсын бүртгэлийн үйлчилгээг авахад иргэдэд дэмжлэг үзүүлэх, зааварчилгаа өгөх
- 13 сум, 1 тосгоны шинээр томилогдсон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг дарга нар болон Тамгын газрын дарга нарт Улсын бүртгэлийн ерөнхий хууль, бусад хууль эрх зүйн актын хүрээнд анхаарах асуудлуудын талаар зөвлөмж чиглэл өгөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг сайжруулах,
- Онцгой нөхцөл байдал үүсэх болзошгүй аюулаас хамгаалах, сэргийлэх цахим эрх зүйн сургалт

- Төрийн албан хаагчийн ёс зүйн ба улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт
- Улсын бүртгэлийн байгууллагын хууль тогтоомж болон холбогдох бусад хуулийн талаар ойлголт
- МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ажиллах улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад Эрх зүйн сургалт
- Сонгуулийн ирц бүртгэлийн программын сургалт
- Иргэний улсын бүртгэлийн шинэ програмд бүртгэл хөтлөлт, хууль журмын хэрэгжилт зэрэг хэлтсийн 2021 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 29 удаагийн сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж ажиллав.



#### Тайлагнасан ажлууд

- Төрийн захиргааны албан хаагчийн 2020 оны ХАСХОМ-ын нэгдсэн тайлан,
- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт
- Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2021-2022 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
- Хүний эрх, хүн худалдаалахтай тэмцэх
- Терроризмоос урьдчилан сэргийлэх
- Жендэрийн тэгш байдлыг хангах ажлын төлөвлөгөөний биелэлт
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
- Аймгийн Засаг даргын 01 тоот үүрэг даалгаврын биелэлт
- Ковид-19 вакцинжуулалт, өдөр бүрийн 15 цагийн мэдээ
- Монгол бичгийн тайлан
- Мэдээллийн ил тод байдлын тайлан
- Мэдээллийн самбар байршуулсан талаарх тайлан
- Инфографик мэдээллийг байршуулсан талаарх тайлан
- Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн дэлгэрэнгүй мэдээ
- Гэрчилгээ, үнэмлэхийн үнэт цаас, маягтын сар бүрийн зарцуулалтын тайлан
- Төсвийн гүйцэтгэл, үйлчилгээний орлогын тайлан
- “Зөв зөвд шударга зөв” аяны тайлан
- Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх сар бүрийн тоон мэдээг УБЕГ-т хүргүүлж ба хэлтсийн цахим хуудасны тоон мэдээ цонхонд тогтмол байршуулан ажиллаж байна.



## Арав. Идэвх санаачлага, шинэлэг ажил

Аймгийн Прокурорын газар, Мобиком оператортай хамтран төлөвлөгөө гаргаж ажиллаж байгаа бөгөөд 25,45 насны иргэдийн иргэний үнэмлэхний хугацааны сунгалтын бүртгэлд хугацаанд хамрагдах сануулах мессежийг 1322 иргэдийн утсанд илгээж бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх томоохон ажил хийж байгаа болно.



Мөн 16 насанд хүрч биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр бүртгүүлж иргэний үнэмлэх анх удаа авах, 25, 45 насны иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацааны сунгалт хийлгэх иргэдийн судалгааг сумын хэмжээнд баг тус бүрээр нь гаргаж, багийн дарга нартай хамтран тухай бүр мэдэгдэж, урилга өгч, иргэдийг хуулийн дагуу тогтоосон хугацаандаа бүртгэлд хамрагдахыг зөвлөж, сургалт сурталчилгаа тогтмол хийж ажиллаж байна.

“Хууль зүйн салбарын нээлттэй бодлого” баримт бичгийн хүрээнд 2021 онд Улсын бүртгэлийн еранхий газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Уг төлөвлөгөөнд “Төрийн үйлчилгээ авахтай холбоотой улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж буй хаяг байршил, бичиг баримтын бүрдүүлэлт, үйлчилгээний үнэ хураамжийн талаарх мэдээлэл агуулсан самбарыг холбогдох үйлчилгээний байранд байршуулж иргэдийг мэдээллээр хангах” гэж заасны дагуу тус хэлтэс нь үйлчилгээний заал, архив, төвийн албан хаагч бүрийн үйлчилгээ үзүүлэх цонхонд мэдээ мэдээллийн самбар байршуулан ажиллаж байна.



Өндөр настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дараалал харгалзахгүй үйлчилгээ үзүүлдэг зэрэг байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон стандартад нийцүүлэн байршуулсан болно.

Үйлчилгээний стандартын шаардлага хангасан хэлтсийн албан өрөөнүүдийн нэр хаягийг монгол бичиг болон кирилл бичгээр бичиж өрөөний үүдэнд байршуулсан.



Сумдын Засаг даргын тамгын газартай хэлтсийн дарга хамтран ажиллах хүрээнд сум дахь улсын бүртгэлийн мэдээллийн самбарыг шинэчилэн нэгдсэн нэг стандартад нийцүүлэн баталж өгч, сумын төсвөөр 10 сум мэдээллийн самбар хийлгэсэн бол 3 сум захиалга өгсөн байна.



Тухайн мэдээллийн самбарт хууль тогтоомж, тушаал шийдвэр, улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон, бүрдүүлэх баримт бичиг, ажиллах цагийн хуваарь, зарлал гэсэн агуулгатай ба үүнд:

1. Хууль тогтоомж: Улсын бүртгэлийн ерөнхий хууль, иргэний улсын бүртгэлийн тухай хууль,
2. Тушаал шийдвэр: Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт, үйлчилгээний хөлсний талаар гарсан тогтоол, тушаал,
3. Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олонд манай хэлтсийн танилцуулга,

4. Улсын бүртгэгчийн мэдээлэл хэсэгт бүртгэгчийн хийх бүртгэл, цагийн хуваарь,
5. Бүрдүүлэх баримт бичиг: бүрдүүлэх материалын жагсаалт брошур,
6. Ажиллах цагийн хуваарь хэсэгт цагийн хуваарь хэлтсийн хаяг веб сайт гэх мэт
7. Зарлал хэсэгт өдөр тутмын иргэдтэй хүргэх зар мэдээ мэдээллийг тавьж байгаа.

Мөн шинэчлэгдсэн гарсан тушаал, шийдвэр, журам, мэдээ мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулан ажиллаж байна.

Зарим сумын улсын бүртгэгчид маань өөрсдөө санаачлан иргэдэд үйлчлэх ширээтэй булан ажилуулж, тараах материал байршуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой хууль, тогтоомж бүртгэлийн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор тус аймгийн 13 сум, 1 тогсоны сумын бүртгэгч нар өөр өөрсдийн сумдад цахим мэдээллийн вэб пейж хуудас нээн тогтмол ажиллуулж улсын бүртгэлийн талаарх хууль тогтоомж журмуудыг сурталчилан, орон нутгийн ард иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллаж байна. Тухайлбал Буянт сумын улсын бүртгэгч цахим үйлчилгээний вэб блог [ebuyant.wordpress.com](http://ebuyant.wordpress.com), пэйж хуудас **e-buyant** нээн хөгжүүлж байна. Энэхүү цахим үйлчилгээний онцлог нь иргэд захиалсан үнэмлэхээ ирсэн үгүйг цахимаар хайлт хийж харах боломжтойгоос гадна үйлчилгээтэй холбоотой иргэдийн санал хүсэлтийг цахимаар хүлээн авах боломжийг бүрдүүлсэн.

Ковид-19 халдварт өвчин гарсантай холбогдуулан болзошгүй эрсдэлээс урьчилан сэргийлэх зорилгоор албан хаагчид ашиглаж буй техник хэрэгсэл болон албаны өрөөнд ариутгалын бодисоор хийх их цэвэрлэгээний төлөвлөгөө батлан гаргаж, тогтмол цэвэрлэгээ, ариутгал хийв. Мөн өглөө бүр хэлтсийн харуул хамгаалалтын ажилтан хэлтсийн албан хаагчдын халууныг хэмжин ажиллав.



Хэлтсийн даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрий А/11 дүгээр тушаалаар “Эцэг эхийн зөвлөл”-ийг 3 гишүүнтэйгээр байгуулж, эцэг эхийн зөвлөл нь хүүхэдтэй холбоотой бүхий арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: Ковид-19 вирусын халдварт өвчний цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хүүхдийн баярыг тохиолдуулан цахим уралдаан зарлаж, амжилттай оролцсон хүүхдүүдэд шагнал гардуулав.





2021 оны 06-р сарын 23-ны өдөр аймгийн төрөх тасагт мэндэлсэн Гурван ихэр хүүхдийн төрсний гэрчилгээг бэлэг, дурсамжийн хамт ёслолтой хүлээлгэн өгч хүндэтгэл үзүүлэв.

“Хоггүй Өлгий-Цэмцгэр хот” бүх нийтийн их цэвэрлэгээнд 2 удаа оролцож хуваарьт газрыг цэвэрлэсэн ба мод тарих ажилд 2 удаа идэвхтэй оролцож 63 мод тарив.



БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 13 сум 1 тосгоны улсын бүртгэгч нарт компьютер, принтер, канон, сканер, хурууны хээ уншигч, зургийн аппарат зэрэг иж бүрэн тоног төхөөрөмжийг сумын улсын бүртгэгч нарт хүлээлгэн өглөө.




Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагааны 3-р улирлын төлөвлөгөөнд тусгаж бүртгэлийн архивт хувийн хэргийн тооллогыг хийж гүйцэтгэлээ.



Хэлтсийн байртай болох асуудлаар удаа дараа санал дэвшүүлэн, холбогдох материалыг УБЕГ-т хүргүүлсэн. Хэлтсийн байр барих байгууллагын эзэмшлийн газрын хэмжээг аймгийн Засаг даргын захирамжаар нэмүүлж, улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээ авч баталгаажуулсан. Мөн байрны зураг, техникийн нөхцөл, архитектур даалгавар, төсвийн урьдчилсан тооцоолол гарсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараар ахлуулсан ажлын хэсэг 2021 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Баян-Өлгий аймагт ажиллах үеэр Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаа, ажлын байрны нөхцөл байдалтай танилцаж, тулгамдаад байгаа тус хэлтсийн байрны асуудлыг аймгийн архивын тасгийн хамт ирэх оны улсын төсвийн салбарын хөрөнгө оруулалтаар стандартын шаардлага хангасан байртай болгохоор дэмжсэнээр хэлтсийн барилгын төсвийг ирэх 2022-2023 онуудад тусгуулж, 6.2 тэрбум төсөвт өртөгийн өөрийн бие даасан архив, ажлын байртай болох боломж бүрдэв.



Монгол Улсын санаачлагаар хэрэгжүүлж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжиж гарын үсэг баталгаажуулан, Өлгий сумын Ногоон байгууламжийн талбайд хамт олноороо мод тарив.





Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 81 жилийн ойг тохиолдуулан улсын бүртгэлийн хэлтсээс 2021.11.22, 23-ний өдрүүдэд НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ болон ҮЗЭСГЭЛЭН зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгөөр

- Emongolia аппликейшний танилцуулга
- Emongolia-д орсон бүртгэлийн үйлчилгээний талаарх танилцуулга
- Анх удаа иргэний үнэмлэх авч байгаа 16 настангуудад цахим үнэмлэх гардуулах "Андгай өргөх ёслол",
- Бичиг баримтын үүсэл хөгжилтэй холбоотой үзэсгэлэн
- Түүхэн зургийн үзэсгэлэн
- шинээр мэндэлсэн хүүхдээ бүртгүүлсэн эцэг, эхчүүд, гэрлэлтээ батлуулсан залуу хосууд болон бүртгэлийн үйлчилгээ авсан иргэдэд гэрчилгээг нь ёслолтой гардуулан түргэн шуурхай үзүүлэн ажиллав.



Ойн баярыг угтан зохион байгуулсан Нээлттэй хаалганы өдөрлөгийг Төрийн далбаанд хүндэтгэл үзүүлснээр эхэлж, хэлтсийн дарга Т.Заманбек салбарын ололт амжилт, хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, emongolia цахим үйлчилгээний талаар танилцуулга хийсэн бол аймгийн ЗДТГ-ын дарга Б.Мухамед, аймгийн тамгын газрын Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Тиянах нар хүрэлцэн ирж баярын мэндчилгээ дэвшүүлж үг хэлж, аймгаас гарсан аливаа шийдвэр, чиглэлийг байнга дэмжин, бусад байгууллагуудыг манлайлан ажилладагыг онцлон хэлж, жилийн эцсээр ажил дүгнэхэд онцгой анхаарах талаар дурдаж, хэлтсийн алба хаагчдын ажилд амжилт хүсэн ерөөж, зарим албан хаагч нарыг шагнаж урамшуулав.



Байгууллагын нийт албан хаагчдад авлигыг тэвчих, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг өдөр тутмын үйл ажиллагаа, хэрэгцээ болгон ажиллах, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэх, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлээ илэрхийлж, төрийн үйлчилгээг иргэдэд ил тод, нээлттэй, хүнд сурталгүй хүргэж ажиллахыг үндсэн зорилтоо болгож ажиллахыг ураилан ажиллаж байна. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулагдаж буй “Зөв зөвд шударга зөв” соён гэгээрүүлэх аянд нэгдэж АТГазраас ирүүлсэн брошур, сурталчилгааны материалыг хэлтсийн үйлчилгээний танхимд байршуулж, цахим хуудас болон нийгмийн сүлжээгээр олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулав. Албан хаагчдыг Авлигатай тэмцэх газрын АТГ - Олон Нийтийн Төв фэйж хуудсанд Like дарж нэгдэн орж тогтмол мэдээлэл авч байгаа болно.



Бүртгэлийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс холбогдох байгууллагуудтай хамтран үйлчилгээний танхимд тэргэнцэр, түшүүртэй хөдөлгөгч /гар таяг/ байршуулж зарим нэр төрлийн үйлчилгээ авах хүсэлтийг 70427810 тоот утас болон <https://www.facebook.com/bayanulgi.burtgel> пэйж хуудсаар хүлээн авч гэр, ажлын байранд очиж 15 иргэнд үзүүлэн ажиллав.

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

9005935  
ГСТ7153 0221020031